



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2022 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 57

Улаанбаатар хот

Банк бус санхүүгийн гадаад валютын арилжаа  
эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, 14 дүгээр зүйлийн 14.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 370 дугаар тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд эрдээлд суурилсан хяналт шалгалт хийх журам”-ын 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Экспресс финанс сервис ББСБ” ХХК-ийн банк бус санхүүгийн гадаад валютын арилжаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2. “Экспресс финанс сервис ББСБ” ХХК-ийн банк бус санхүүгийн гадаад валютын арилжаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбогдуулан тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд өөрчлөлт хийлгэхийг “Экспресс финанс сервис ББСБ” ХХК /Д.Бямбадулам/-д анхааруулсугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийт болон харьяалагдах татварын алба, Улсын бүртгэлийн ерөнхий газарт ажлын 10 хоногийн дотор мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН



151800000125